

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2019.01.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид 12 дугаар сард 2 удаа хуралдаж 4 асуудал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 4 удаа хуралдаж, 20 гаруй асуудал хэлэлцлээ. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар:

-Сэлэнгэ аймгийн 2019 оны төсөв батлах тухай асуудлыг хэлэлцэн төсвийн орлогыг 73,492,400.7 мянган төгрөг, зарлагыг 73,492,400.7 мянган төгрөгөөр тус тус баталлаа.

-Бэлчээрийн газрын төлбөрийн талаар авах арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцээд бэлчээр хадлангийн талбайн доройтлыг бууруулах хөрсний үржил шимийг хамгаалах зорилгоор мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирэх оны эхнээс эхлэн жил бүр нэг хонин толгойд ногдуулах бэлчээрийн газрын төлбөрийг тухайн газрын тогтоосон суурь үнэлгээний 0.03 хувиар ногдуулан авахаар, орон сууц худалдан борлуулах м2 талбайн үнэ тогтоох тухай асуудлыг хэлэлцээд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Баянханы 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт баригдаж буй “Төрийн албан хаагчдын 120 айлын орон сууцны 1м2 талбайн үнийг 1 067 174 төгрөг байхаар тус тус тогтоов.

-Санал уламжлах тухай асуудлыг хэлэлцээд МУ-ын Засгийн газрын 2018 оны 131-р тогтоолоор Сэлэнгэ аймгийн 16 сумын 44 багийн нутаг дэвсгэр Тариалангийн бүс нутгаар тогтоогдсонтой холбогдуулан Тариалангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалтыг хэрэгжүүлэх, аймгийн хэмжээнд бэлчээр хадлангийн талбайн доройтлыг бууруулах, хөрсний үржил шимийг нөхөн сэргээх зорилгоор Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт уламжиллаа.

Тэргүүлэгчдийн хурлаар:

Ерөө сумын Зурхай засал гэгээрүүлэх дацангийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгаж, Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах журмын төсөл, “Байгаль орчны төлөв байдлын 2016-2017 оны тайланг хэлэлцэн баталж, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлын талаарх Сүхбаатар сумын Засаг даргын мэдээлэл, “Ажлын байр амьдрах ухаан хөтөлбөр”-ийн хэрэгжилт, үр дүнгийн тухай Хөдөлмөр Халамж үйлчилгээний хэлтсийн даргын мэдээллийг тус тус сонсож, Цагдаагийн байгууллагад хяналт тавих үүрэг бүхий Иргэний хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталлаа.

Мөн үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх, үндсэн хөрөнгийг актлаж, данснаас хасах зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тус аймгийн харъяат зарим хүмүүсийг төрийн одон медалиар шагнуулахаар Монгол Улсын ерөнхийлөгчид уламжлахаар шийдвэрлэж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.

2. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Хүйтний эрч чангарч байгаатай холбогдуулан хот суурин газрын халаалтын зуухнууд ачаалал ихтэй ажиллаж байна. Алтанбулаг, Баруунбүрэн, Жавхлант, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул, Сант, Хушаат, Хүдэр, Түшиг, Шаамар сумдын халаалтын зуухнууд 15-30 хоногийн нүүрсний нөөцтэй, Баянгол сумын халаалтын

зуух, Мандал сумын “Сэлэнгэ Зүүнхараа” ОНӨААТҮГ-ын зуух, Сайхан сумын “Хөтөл Цемент шохой” ХК-ий зуух, Сүхбаатар сум “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын зуухнууд 3-5 хоногийн нүүрсний нөөцтэй, “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын халаалтын зуух хүндэрч болзошгүй, “Хөтөл Цемент шохой” ХК-ний зуух нүүрс авах төсөв мөнгөгүй гэсэн мэдээлэл өгсөнтэй холбогдуулан холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоол, ХХААХҮС-ын аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар, малчид, мал бүхий иргэдэд хандаж гаргасан зөвлөмж, аймгийн Засаг даргын 2018 оны 10 тоот албан даалгавраар өгсөн үүрэг чиглэлийн дагуу өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулах зорилгоор ажлын төлөвлөгөө гаргаж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүлээн авах, үр дүнг тооцох, хадлан тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулж хээлтүүлэгч малын хүрэлцээ хангамжийг тооцож дутагдахыг нөхөн тавих, бэлчээр ашиглалтыг сайжруулах үүрэг чиглэлийг сумдад өгч хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2018-2019 оны өвөл, хавар 17 сумын 56 багт, 9499 малчинболон мал бүхий өрхөд 1.6 сая мал өвөлжихөөр зохион байгуулалтын арга хэмжээ авч, 2019 оны 1 дүгээр сарын 2-ны байдлаар өвөлжилт хэвийн, хүндэрсэн сумд байхгүй байна.

Энэ жилийн 2018 оны жилийн эцсийн малын тоо нийт 1.540.036 үүнээс адуу 97604, үхэр 216805, хонь 705874, ямаа 519270, тэмээ 483 тоологдсон дүн мэдээ гараад байна. Аймгийн аюулгүйн нөөцөд 150 тонн өвс, 30 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 842 тонн өвс, 217 тонн тэжээл бэлтгэсэн. Энэ жил цас бага байгаа тул сум, аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг хэрэглэж эхлээгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлыг урамшуулах, ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Хадлан тэжээл-2018” болзолт уралдааныг Улсын хэмжээнд зарласан бөгөөд энэхүү болзолт уралдаанд тус аймгийн Орхонтуул сум хамгийн их хадлан, тэжээл бэлтгэж, мал эмнэлгийн арга хэмжээнд малаа бүрэн хамруулж, өвчлөл гаргаагүй, малаа эдийн засгийн эргэлтэд хамгийн сайн оруулсан, отор нүүдлийн бэлтгэлийг зөв зохистой ханган ажилласан амжилтаар Монгол Улсын 330 сумаа тэргүүлээ. Болзолт уралдааны тэргүүн байрын шагнал өргөмжлөл, 10,0 сая төгрөгийн батламжийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Батмөнх аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцагт гардуулан өглөө.

2018 онд байгаль цаг уурын нөхцөл байдлаас үүдэн ургац хураалтын явцад хүндрэл бэрхшээл тулгарсанч тариаланчид маань өөрсдийн мэдлэг туршлага, техникийн хүчин чадлыг зүй зохистойгоор хуваарилан ашиглаж, аймаг, орон нутгийн хамтын хүч дэмээр төлөвлөсөн ургацаа бүрэн хэмжээнд хураан авлаа. Улаанбуудай 128,6 мянган га талбайд хураалт хийж нэгж га талбайгаас 14,2 цн буюу 182,9 мянган тн, тосны ургамал 17,9 мянган га талбайд хураалт хийж нэгж га талбайгаас 6,8 цн буюу 12,1 мянган тн, тэжээлийн ургамал 14,7 мянган га талбайд хураалт хийж нэгж га талбайгаас 12 цн буюу 17,6 мянган тн, төмс 2654 га талбайд хураалт хийж нэгж га талбайгаас 133 цн буюу 32,1 мянган тн, хүнсний ногоо 2618 га талбайд хураалт хийж нэгж талбайгаас 124,0 цн буюу 31,6 мянган тн ургац хураан авч, Улсын хэрэгцээт үр тарианы 50 орчим хувь, төмсний 28 хувь, хүнсний ногооны 36 хувийг хангасанг амжилтаар “Ургацын баяр”-аа энэ сарын 7-ны өдөр тэмдэглэлээ. Арга хэмжээний үеэр оны шилдгүүдийг шалгаруулсан бөгөөд нэгж га талбайгаас хамгийн их улаанбуудайн ургац авч тэргүүлсэн сум-ХУШААТ сум, нэгж талбайгаас хамгийн их төмс хураан авч тэргүүлсэн сум-ОРХОН сум, нэгж га талбайгаас хамгийн их хүнсний ногоо хураан авч тэргүүлсэн сум-МАНДАЛ сум, газар тариалангийн салбарт хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгж-Зүүнбүрэн сумын “АРВИН ХҮР” ХХК, нэгж га талбайгаас хамгийн их улаанбуудайн ургац хурааж тэргүүлсэн аж ахуйн нэгж-Хушаат сумын “МОМО АГРО” ХХК, хамгийн их жимс жимсгэнэ тариалж хураан авсан аж ахуйн нэгж, иргэн-Шаамар сумын Дулаанхаан тосгоны иргэн С.НАРАНЦОГТ, хөрс хамгаалах чиглэлээр дэвшилтэт арга технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн аж ахуйн

нэгжээр-Хушаат сумын “ӨГӨӨЖ МАНДАЛ УУЛ” ХХК, газар тариалангийн салбарын шилдэг менежерээр-Цагааннуур сумын “ТОВХОН ХАН” ХХК-ий захирал Г.ЭНХБОЛД, газар тариалангийн салбарын шилдэг механикжуулагчаар-Цагааннуур сумын “СЭЛЭНГЭ ТАРИА” ХХК-ий механикжуулагч Ч.ЧИМЭДДОРЖ, шилдэг өрхийн аж ахуй эрхлэгчээр-Сүхбаатар сумын Хонгорморьт 1-р багийн ногоочин Л.АЛТАНЦАГ нар шалгарлаа. Мөн “Сэлэнгэ ургац-2018” арга хэмжээнд зориулсан үндэсний бөхийн барилдаанд улсын харцага н.Бат-Өлзий түрүүлж, улсын заан н.Батмөнх үзүүрлэн, улсын харцага Б.Одгэрэл шөвгөрч, бөхийн барилдааныг “Өег гурил” ХХК ивээн тэтгэж түрүү бөхийг 1,500,000, үзүүр бөхийг 1,000,000, шөвгөрсөн бөхийг 500,000 төгрөгөөр байллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт нэвтрүүлсэн ISO 9001-2015 Олон Улсын стандартын гүйцэтгэлд хөндлөнгийн аудит хийх Стандарт, хэмжилзүйн газрын ахлах мэргэжилтэн Г.Эрдэнэбилэг, Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрын ахлах мэргэжилтэн Б.Мөнгөнбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг энэ сарын 13, 14-ны өдрүүдэд тус аймгийн Засаг даргын Тамгын газарт ажилласан бөгөөд давтан хамгаалалтын хуралд энэ сарын 28-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга амжилттай оролцлоо.

Нутгийн захиргааны байгууллагуудын төрийн захиргааны 57 сул орон тоог аайгууллага, албан тушаал, түүнд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг бусад мэдээллийн хамт www.selenge.gov.mn, www.csc.gov.mn зэрэг цахим хуудсууд, $\hat{i} \hat{o} \hat{i} \hat{i}$ $\hat{i} \hat{o} \hat{a} \hat{e} \hat{e} \hat{i}$ $\hat{i} \hat{u} \hat{u} \hat{u}$, $\hat{i} \hat{u} \hat{u} \hat{u} \hat{e} \hat{e} \hat{e} \hat{i}$ хэрэгслээр нийтэд ил, тод зарлан 12 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд бүртгэж, 173 иргэн бүртгүүлсэн. Шалгалтыг 13-ны өдөр зохион байгуулж, 169 хүн оролцож, 68 иргэн буюу 40,2 хувь нь тэнцсэн.

Байгаль орчны салбарын ажилтан, албан хаагчид 2018 оны ажлаа дүгнэж, 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлаа тодорхойлсон сургалт, зөвлөгөөнийг 12-р сарын 19-нд зохион байгууллаа. Сургалт, семинарт сумдын байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, сум болон сум дундын ойн ангийн дарга, инженер, техникчид хамрагдаж, БОАЖЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын хуулийн хэлтсийн мэргэжилтэн, Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн ахлах мэргэжилтнүүд оролцож мэргэжил арга зүй, хууль тогтоомж, эрхзүйн мэдээллийг өгч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага нэмэгдснийг онцолж, байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлж ажиллахдаа төрийн албаны нэр хүндийг өндөрт өргөж, улс төрийн нөлөөлөл, авлига ашиг сонирхолоос ангид байж иргэдэд чирэгдэлгүй үйлчилж байх талаар аймгийн Засаг даргаас өгсөн чиглэлийг хэрэгжүүлж, ой, хээрийн түймрийг гарсны дараа биш гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэх ажлыг сайн зохион байгуулах, ажлын цаг ашиглалтын үр нөлөөг өндөржүүлэх, ажилдаа идэвхи санаачлагатай, сэтгэл зүтгэлтэй ажиллах, аймгийн ИТХ-аас гаргасан “Ойн дэд хөтөлбөр”, “Сэлэнгэ-Ногоон бүс нутаг хөтөлбөр”, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”, “Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр”-үүд, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Байгаль орчны бодлого, шинэчлэлийн хүрээнд хийгдэхээр тусгагдсан ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болголоо.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх асуудлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд тус салбарт ашиглагдаж буй автомашины судалгааг үндэслэн Баруунбүрэн, Сант сумдын Эрүүл мэндийн төвийг автомашинтай болгож, энэ сарын 3-ны өдөр гардуулан өглөө.

Онцгой байдлын газрын ажил үйлчилгээний талаар:

Хүйтний улирал эхэлж айл өрхүүдийн пийшин зуухны галлагаа болон цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор объектын гал түймрийн гаралт нэмэгдэх хандлагатай байна. Иймд болзошгүй гал түймрийн аюулаас

урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, пийшин зуухны хэт галлагаа, цахилгаан хэрэгслийн аюулгүй ажиллагааг хангуулах үүднээс иргэд, айл өрхүүдэд урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа, сэрэмжлүүлэг зөвлөмж өгөх, иргэдийн галын аюулгүй байдлыг хангуулах, гал түймрийн тоо, хохирлыг бууруулах зорилгоор болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2018 оны 12 дугаар сарын 03-ний өдрөөс 12 дугаар сарын 10-ний өдрүүдэд зохион явууллаа. Нэгдсэн арга хэмжээний хугацаанд Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сум дахь Гал түймэр унтраах, аврах анги, Улсын нөөцийн салбар, Эрэн хайх, аврах ангийн бие бүрэлдэхүүн болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, пийшин зуухны галлагаа, цахилгаан хэрэгсэл, хийн баллоны аюулгүй байдлыг хангах талаар 2172 айл өрхийн пийшин зуух, цахилгаан хэрэгсэл, хийн плитка, өвс хадлан тэжээл, өвөлжөө хашаа саравчийг үзэж шалган дээрх өрхийн 4765 иргэнд илэрсэн зөрчил дутагдалыг арилгах, аюулгүй байдлаа хангах талаар заавар зөвлөмж өгч хангууллаа. Тус арга хэмжээний хүрээнд иргэд олноор цуглардаг худалдаа, үзвэр үйлчилгээ, гудамж талбай, айл өрхүүдээр албан хаагч нар явж иргэдэд болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, мөсөн дээгүүр зорчихгүй байх, цахилгаан хэрэгслийн аюулгүй байдлыг хангах зэрэг сэдэв бүхий 1652 ширхэг сэрэмжлүүлэгийн материалыг тарааж, Сүхбаатар, Мандал, Сайхан, Баянгол сумдын кабелин телевизээр 20-25 удаагийн давтамжтайгаар болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх шторк сэрэмжлүүлгийг нэвтрүүлсэн. Мөн аймгийн Онцгой байдлын газрын se.nema.gov.mn, Сэлэнгэ Онцгой байдлын газар фэйсбүүк хуудсанд 8 удаагийн сэрэмжлүүлэг мэдээллийг байршуулсан.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд Алтанбулаг, Цагааннуур сумдад үзлэг шалгалт, сургалтын арга хэмжээг зохион байгуулж, тус сумдын мэргэжлийн ангийн гал унтраах сайн дурын бүлгийн бэлэн байдлыг үзэж шалган Алтанбулаг сумын 35 иргэн, Цагааннуур сумын 62 иргэнд тус тус бэлэн бай сургалтын багцаас гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг 2 цагийн хугацаатай зохион явууллаа.

Алтанбулаг сумын мэргэжлийн анги, Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүний хамтаар гэр хорооллын гудамжинд байрлаж цугларсан иргэдэд болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэгийн материалыг тараах, мөн гудамж, дэлгүүр, айл өрхүүдээр биечлэн явж сэрэмжлүүлэгийн материалыг тараан зөвлөмж өгөх, шуурхай албаны автомашинаар гудамж талбай болон хилийн бүсэд хүрэлцэн очиж автомашины чанга яригчаар санамж, зөвлөмжийг дамжуулах зэргээр зохион байгуулан нийт 125 иргэнд сэрэмжлүүлэг материал тараах, 25 айл өрхүүдээр орж гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө тус тус өглөө.

Аёл төв Сүхбаатар сумын айл өрхүүдээр үзлэг шалгалтыг зохион байгуулж, 4, 5, 7, 8 айлаар 726 айл өрхийн 1913 иргэнд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж авлаа. Үзлэг шалгалтаар нийт 42 зөрчил илрүүлж 4 зөрчлийг газар дээр нь арилгах арга хэмжээ авлаа.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээний талаар:

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнсний худалдаа, нийтийн хоол, хүнсний үйлдвэрлэлийн нийт 72 объектыг хамруулж, хяналт шалгалтын явцад 50 зөрчил илрүүлж, үүнээс газар дээр нь 38 зөрчлийн арилгуулан дуусах хугацаа хэтэрсэн хаяг шошгын зөрчилтэй 24 нэр төрлийн 558,5 мян/төгрөгний хүнсний бүтээгдэхүүн, үйлдвэрлэсэн хугацаа тавигдаагүй 16 нэр төрлийн 238ш, 234,3 мян/төгрөгний буцаан татан авалт хийлгэж, импортын болон дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар,

аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөгөө зөвлөмж, сэрэмжлүүлгийг өгч, байгууллагын сургалтуудыг зохион байгуулж байна.

Шинэ жилийн баярт зориулан худалдаалж байгаа түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлтийн байдалд хяналт тавьж, тээвэрлэлтийн улмаас чанар байдал нь алдагдсан бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийлгэж, хэрэглэх хугацаа хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүн, хаяг шошгын зөрчилтэй, гарал үүсэл нь тодорхойгүй, шинжилгээний баталгаажилтгүй, ялангуяа хүүхдийн сонирхолыг татсан хүнсний бүтээгдэхүүн, чихэр зэрэг бүтээгдэхүүн байгааг анхаарч хүүхдийн бэлгийг сонгохдоо бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал дээр хяналтаа тавьж худалдан авахыг зөвлөж ажиллалаа.

Сайхан сумын “Хөтөл жимсгэнэ” хиамны цех, Сүхбаатар суманд үйл ажиллагаа эрхэлдэг “Залуус” бейкери бялууны үйлдвэрлэлд технологи дамжлага, түүхий эд, нэмэлт, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт шалгалт хийж, худалдаанд гаргах хүртэл технологийн дамжлагат дотоодын хяналтыг сайжруулах, хаяг шошгын стандартыг хангаж ажиллах талаар зөвлөмжийг өгч хяналт тавин ажиллаж байна. Мөн удирдамжийн хүрээнд байгууллага хамт олны хүлээн авалт хийх нийтийн хоолны 27 газрын үйл ажиллагаа, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт шалгалтыг хийж, шалгалтын явцад 25 зөрчлийг илрүүлэн 18 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 2 объектод хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг тооцож байна.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн тухай мэдээлэл болон илэрч байгаа зөрчлүүдийн талаар зөвлөмж сэрэмжлүүлэг өгч, аймгийн фэйсбүүкд 13, вэб хуудсанд 13 удаагийн мэдээ мэдээлэл, 13 постер зөвлөмжийг байршуулан selengezar фэйсбүүк группт сурталчилж, хүнсний чиглэлээр 2 удаа сургалтыг зохион байгуулж, сургалтанд 25 иргэд, аж ахуйн нэгж хамрагдаж, 5 нэр төрлийн 52 зөвлөмжийг тарааж, плакатуудыг байршуулсан. 185 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн.

Мөн тайлант сард Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөтөл, Сэлэнгэ салбаруудын хүнсний улаанбуудайн хүлээн авсан 3 сортын 1950 тонн үрийн улаанбуудай, Онцгой байдлын газрын Орхонтуул салбарын үрийн нөөцийн нэгжид 1 сортын 500 тонн үрийн улаан буудайнд хяналт шалгалтыг хийж дүгнэлт гарган ажиллалаа. Хөтөл салбарт үрийн буудай хадгалах зориулалт бүхий 2000 тоннын хэвтээ агуулах ашиглалтанд орсонтой холбогдуулан агуулахын ариутгал халдваргүйжүүлэлт хийхэд хяналт тавьж газар дээр нь очин зөвлөгөө зөвлөмж өглөө.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 3 дугаар багийн Дулаанхаан тосгонд баригдсан Зөгийн зорь, Сайхан суманд баригдах 480 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, Сайхан сумын ТЭДСангийн үрийн буудайн хэвтээ агуулахын барилгын ажлын зурагт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт улсын байцаагчийн 3 дүгнэлт үйлдэн холбогдох газарт хүргүүлэн ажиллалаа. Мэргэжлийн хяналтын газрын даргын 2018 оны 12-р сарын 25-ны өдрийн 18-02-033/039 дугаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд Алтанбулаг сумын нэр бүхий иргэний ирүүлсэн гомдлын дагуу “Заяа” зоог, “Энхдөл” зоог, малын мах, сүү цагаан идээ худалдаалдаг 3 газарт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчдын хамтарсан албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Стандарт, хэмжил зүйн салбарын түүхт 95 жилийн ойг тохиолдуулан аймгийн Засаг даргын ивээл дор “Дурсамж, зөвлөмж, туршлага” ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулж, орон нутгийн стандарт, хэмжил зүйн байгууллагад ажиллаж байсан үе үеийн удирдлагууд, ахмад ажилтнууд, одоо ажиллаж байгаа болон ажиллаж байсан ажилтан, албан хаагчид оролцон, түүхэн цаг үеийн талаар ярилцаж, ахмад ажилтнуудынхаа дурсамж яриаг сонсож, харилцан туршлага солилцсон сайхан арга хэмжээ боллоо. Мөн Стандарт, хэмжил зүйн салбарын 95 жилийн ойг тохиолдуулан орон нутгийн “Миний Монгол” телевизтэй хамтран хэлтсийн үйл ажиллагааг сурталчилсан нэвтрүүлэг бэлтгэн гаргалаа.

Сүхбаатар суманд газрын тосны бүтээгдэхүүн худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн шатахуун түгээх станцын бүтээгдэхүүний чанар, үнэ тариф, түгээгүүрийн шахалт, түүний хэмжлийн нэгдмэл байдал мөн үйлчилгээнд Мэргэжлийн хяналтын газар, Аймгийн Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл, Ашигт малтмал Газрын тосны газрын Сэлэнгэ аймаг дахь төлөөлөгч, Стандарт, хэмжил зүйн хэлтсээс хамтран хяналт шалгалтийг хийлээ. Шалгалтаар ШТС-ын түгээгүүрийн шахалтын эталон мерникээр шахаж, худалдан борлуулж байгаа автобинзиний октаны тоо, дизелийн түлшний цетаны тоо хэмжээг тодорхойлох шинжилгээг газар дээр нь хийлээ. Шалгалтын явцад шатхуун түгээгүүрийн шахалт хэвийн автобинзиний октаны тоо, дизелийн түлшний цетаны тоо зөвшөөрөгдөх хэмжээндээ байна.

Тайлант сард Баянгол, Зүүнбүрэн, Сайхан, Ерөө, Сүхбаатар, Хушаат, Хүдэр, Мандал сумдын 19 аж ахуйн нэгж, иргэний 5 хүнсний дэлгүүр, 1 минимаркет, 1 гэр ахуйн бараа, бэлэг дурсгалын дэлгүүр, 6 караоке баар, 1 кафе, 1 цайны газар, 1 түргэн хоолны цэг, 1 хүнсний мухлаг, 1 үсчин, 1 бильярдын үйлчилгээнд МУ-ын “Худалдааны газар, түүний үйлчилгээ үндсэн шаардлага MNS 5021:2007”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага MNS 4946:2005”, “Бильярдын үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 6001:2009”, “Үс засах үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5160:2002” стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.

Ерөө сумын “Моностойн нуруу” ХХК-ийн үйлдвэрлэсэн “Ноёт” сортын арвайн гуриланд тохирлын гэрчилгээ олгож, Мандал сумын “Мөнх Ану” цехэд үйлдвэрлэсэн хөлдөөсөн бууз, хэрчсэн гурил, Сайхан сумын Номгон 3-р багийн иргэн Г.Баярсайханы үйлдвэрлэсэн шарсан тахиа, шаржигнуур тахиа, тахианы махан котлет зэрэг бүтээгдэхүүнийг аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн сорилтын лабораторийн шинжилгээнд хамруулж, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж өглөө. Мөн 3 өрхийн үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэж буй 2 нэрийн 6 бүтээгдэхүүний хаяг шошгыг хянаж холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулах талаар мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан.

Стандартын салбар сангаас 5 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 4 нэрийн 5 стандартаар хангаж, аргазүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Сорилтын лабораторид 34 нэрийн 34 стандартаар хангах үйлчилгээ үзүүлж, 383960 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Хэмжил зүйн лаборатори нь эзлэхүүн хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын “НИК” ХХК-ий 1 шатахуун түгээх газрын 2 түгээгүүрийн шингэн хэмжигчийг ээлжит баталгаажуулалта, механик хэмжлийн төрлөөр “Цемент Шохой” ХХК-ий үйлдвэр болон сорилт шинжилгээний жин, 42 ш туухай, 1 авто пүүг, Сүхбаатар сумын худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 3 ш жинг, дулаан даралтын төрлөөр эмнэлэг, эмийн сангийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 4 термометр, уурын зуухны 2 термометрыг шалган баталгаажууллаа.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол Улсын Их Хурлаас 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр баталсан Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд тусгагдсан зарим онцлог арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд өгсөн чиглэлийг баримтлан аймгийн 2019 оны төсвийн төслийг Сангийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 4-1/7297 албан тоотоор ирүүлснийг Сэлэнгэ аймгийн 2019 оны төсвийн суурь орлого, зарлагын тооцоололд үндэслэн боловсруулсан.

Санхүүчдийн баярын арга хэмжээг 12 дугаар сарын 07-нд зохион байгуулж, санхүүгийн салбарын ТОП-9 номинаци шилдэг санхүүчдийг шалгаруулж, Сангийн яамны хүндэт тэмдгээр 5, нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан 22, санхүү

банкны тэргүүний ажилтан 13, Сангийн яамны жуух бичгээр 34 хүний шагналыг гардууллаа.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		74.302.918.0	71.551.182.3	96.3
1.1	Орон нутгийн төсвийн орлого	16.880.163.8	16.042.025.1	95.0
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	13.093.499.9	11.723.638.7	89.5
	Сумдын төсвийн орлого	3.786.663.9	4.318.386.3	114.0
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	6.300.000.0	6.300.000.0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	42.897.531.6	42.897.531.6	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	3.407.672.1	3.407.672.1	100.0
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	2.761.970.3	2.761.970.3	100,0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	141.983.2	141.983.2	100.0
1,7	Төсөвт байгууллагын өөрийн орлого /сум хөгжүүлэх сан орсон/	1.913.597.0	1.277.544.0	66.8
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		74.302.918.0	66.847.681.6	90.0
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	74.302.918.0	66.847.681.6	90.0
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	10.402.886.0	9.470.489.7	91.0
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	2.999.542.6	1.268.661.4	42.3
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	18.272.580.6	15.183.132.9	83.1
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	3.032.394.1	2.161.744.0	71.3
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	488.376.0	376.113.2	77.0
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	2.225.637.2	1.473.676.4	66.2
	Халамжийн сан	8.523.244.7	8.061.846.9	94.6
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	3.729.704.8	2.837.443.3	76.1
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	273.223.8	272.309.1	99.7
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	40.070.270.9	38.582.485.7	96.3
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	2.557.637.9	2.342.912.0	91.6
	3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		50.185.160.6	50.126.051.6
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4.360.741.8	4.301.632.8	98.6
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1.860.629.1	1.860.629.1	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	120.385.1	120.385.1	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	317.595.1	317.595.1	100.0
	Хөрөнгө оруулалтын зардалд	1.422.648.9	1.422.648.9	100.0
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1.425.919.1	1.425.919.1	100.0
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	1.422.648.9	1.422.648.9	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	3.270.2	3.270.2	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	39.987.274.4	39.987.274.4	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	2.550.596.2	2.550.596.2	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	42.537.870.5	42.537.870.5	100.0

	- Ерөнхий боловсролын сургууль	21.630.935.2	21.630.935.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	10.990.658.5	10.990.658.5	100.0
	- Соёлын байгууллага	2.817.455.7	2.817.455.7	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	997.203.0	997.203.0	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	5.383.826.8	5.383.826.8	100.0
	- Газрын кадастрын байгууллага	365.526.0	365.526.0	100.0
	- Хүүхдийн байгууллага	352.265.3	352.265.3	100.0
	4. Тусгай сангуудын зарлага	1.877.991.7	567.264.2	30.2
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1.877.991.7	567.264.2	30.2

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2018 X - сар	2018 XI- сар	2018- XI 2018- X/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 200	1 200	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 200	109.1
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6000	6000	100.0
	Үхрийн мах /кг/	6500	7000	107.7
	Адууны мах /кг/	5800	5800	100.0
	Ямааны мах /кг/	5 000	5 000	100.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 000	3 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 000	1 500	150.0
	Сүү / савласан, л/	2 600	2 600	100.0
	Тараг /задгай, л/	1 200	1 600	133.3
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	13 000	100.0
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	2000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1000	1000	100.0
	Лууван /кг/	1200	1200	100.0
	Манжин /кг/	1200	1200	100.0
	Байцаа /кг/	1500	1500	100.0
	Сонгино /кг/	1500	1500	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 300	100.0
7	ШАТАХУУН			

Бензин А - 80	1 835	1 835	100.0
Бензин А - 92	1 985	1 885	95.0
Дизелийн түлш	2 375	2 375	100.0

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Зүүнбүрэн, Ерөө, Жавхлант сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон 2018 оны 10, 43, 19 тоот тогтоолуудыг хуулийн хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтэст бүртгүүлэхээр хүргүүлсэн.

Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, цагдаагийн дэд хурандаа, хууль зүйн ухааны доктор Б.Цолмонг “Адууны туурай криминалистикийн адилтгал болон онош зүйн шинжилгээний объект болохыг тогтоох” нь сэдэвт төслийн танилцуулга, хэлэлцүүлгийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж аймгийн Цагдаагийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Шүүхийн шинжилгээний албатай хамтран ажилласан.

“Архидалттай тэмцэх аймгийн хөтөлбөр”-ийн 1 дүгээр үе шат 2015-2017 онд хэрэгжиж дууссантай холбогдуулан сум, агентлагуудад чиглэл өгөн хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар 84,1 хувийн биелэлттэй тайлагналаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтсээс 12 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 181 бичиж, лавлагаа 2, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 76, лавлагаа 53 олгож үйлчиллээ.

12 дугаар сард иргэний бүртгэлийн талаар:

- ✓ Төрсний бүртгэл – 182 /эрэгтэй-83, эмэгтэй-99/
- ✓ Гэрлэлтийн бүртгэл – 36
- ✓ Гэрлэлт цуцалсны бүртгэл – 15
- ✓ Үрчлэлт - 10
- ✓ Эцэг тогтоолт – 68
- ✓ Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 11
- ✓ Нас баралт – 57
- ✓ Нийт олгосон иргэний үнэмлэх – 514
- ✓ Шинээр олгосон иргэний үнэмлэх – 152
- ✓ Дахин олгосон иргэний үнэмлэх – 155
- ✓ Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 207
- ✓ Гадаад паспорт олголт – 106
- ✓ Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 153
- ✓ Хот доторх шилжилт хөдөлгөөн – 162 тус тус бүртгэгдсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

"Багшийн хөгжлийг дэмжих тухай" хуулийг сурталчлах, “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”, “Багшийн хөгжил, байгууллагын менежмент” сэдвүүдээр удирдах ажилтны сургалтыг БМДИ-тэй хамтран зохион байгуулж, сургуулийн захирал, сургалтын менежер, БСУГ-ын мэргэжилтнүүд 90 хүнийг оролцууллаа.

Боловсрол, соёл, урлагийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2018 оны 12 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд Алтанбулаг, Шаамар, Жавхлант сумд, Дулаанхаан тосгоны ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төвүүдэд зөвлөн туслах чиглэлээр ажиллаж, 137 багшид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, 24 хичээлд ажиглалт хийлээ.

АНУ-ын ЭСЯ-ны Олон нийттэй харилцах албатай хамтран “АНУ-д тэтгэлгээр сурах боломж, сурагч солилцоо болон мэргэжил сонголт”-ын тухай мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулж, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 7 сургуулийн ахлах ангийн сурагчид болон англи хэлний багш нарыг хамрууллаа.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын лаборатори 4-р сургуулийн тэргүүлэх зэрэгтэй, англи хэлний багш Б.Сүхмаагийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа Орхон бүсэд зохион байгууллаа.

БСШУСЯ-наас “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, бүлгийн багш, туслах багш, хоол зүйч, тогооч, хэл засалч зэрэг ажлын байрны тодорхойлолтын төслийг хэлэлцүүлэн саналыг яаманд хүргүүллээ.

6 багшийн мэргэжлийн зэрэг, 96 кабинетийн гэрчилгээг олгосон.

Аймгийн ИТХ-аар тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага болох ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2019 оны төсвийн төслийг батлагдсан төсвийн хүрээнд хуваарилан, хэлэлцүүлэн батлуулж сар улирлын хуваарийн саналыг нэгж байгууллагаас авч нэгтгэн аймгийн ЗДТГ-ын Төрийн сан болон харьяа яамандаа хүргүүлээд байна.

МУ-ын спортын мастер Ч.Үнэнмөнхийн нэрэмжит Чөлөөт бөхийн өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 15 байгууллагын 314 тамирчид 31 жинд өрсөлдснөөс Багийн нэгдсэн дүнгээр 1-р байрыг Д.Сэрээтэрдан дасгалжуулагчтай “Сайхан сум” 65 оноогоор, 2-р байрыг Л.Баяр-Эрдэнэ дасгалжуулагчтай “Мандал сум” 52 оноогоор, 3-р байрыг Б.Батзаяа дасгалжуулагчтай “Сүхбаатар сум” 48 оноогоор тус тус эзэллээ.

Онцгой байдлын байгууллагын Улсын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн тамирчид оролцож, багийн дүнгээр “Хойд бүс” тэргүүлж, Нийслэлийн Онцгой байдлын газар, “Өмнөд бүс” удааллаа.

Усан спорт сургалтын төвөөс “Би сэлж сурсан” тэмцээнийг амжилттай зохион байгуулж, 8 байгууллагын 80 гаруй тамирчид өрсөлдлөө.

2.Эрүүл мэндийн талаар:

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр “Монгол Улс дахь тамхины хяналтын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг үнэлэх туршилт судалгаа”-ны ажлыг гар утасны “Tobacco Spotter” апп-ыг ашиглан Сүхбаатар сумын 86 төр болон хувийн хэвшлийн байгууллага, бар, ресторонд үнэлгээ хийсэн.

Баруунбүрэн сумын 1, Орхон аймгийн 1 жирэмсэн эхээс 2 амьгүй төрсөн хүүхдүүдийн тохиолдолд магадлан хэлэлцэх хурлыг Орхон бүсийн эрүүл мэндийн төвийн дарга, эмч, эх баригч нарын 35 хүнийг хамруулан зохион байгууллаа.

Сайхан сумын Номгон тосгонд Халдварт болон Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг 12 сарын 22-23-ны хооронд зохион байгуулж, 620 гаруй хүнд үзлэг оношлогоо хийн 421 хүнийг цахим санд бүртгэж, эмчийн хяналтад авлаа.

3.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 6 дуудлага ирж хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлж, 1 кейсийг шийдвэрлэсэн.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Малчин залуучуудын бизнесийн өрсөлдөх чадвар” сургалтыг Олон Улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран зохион байгуулж, 11 сумын 52 залуу малчид хамрагдав.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Гэр бүл цуцлалтын үед хүүхдийн асран хамгаалагчийн чадамжийг тогтоох шинжээчийн дүгнэлт гаргах нэгдсэн аргачлал” сэдэвт сургалтанд 1 удирдах ажилтан, 4 мэргэжилтэн хамрагдлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Би чадна” урлаг, спортын өдөрлөгийг зохион байгуулж 104 иргэн хамрагдаж, аймгийн Засаг даргын нөөц сангаас 640.0 мян төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газраас 969.000 төгрөгийг зарцууллаа.

Гэмт хэргийн хохирогч, гэрч, хууль зөрчсөн хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ээлжит 3 дугаар хуралдааныг зохион байгуулж, 2018 оны ажлын үр дүнг хэлэлцлээ.

Аймгийн хэмжээнд “Оны шилдэг хүүхэд” шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж, “Оны онцлох хүүхэд”-ээр “Техник сэтгэлгээ, шинэ санаачилга” номинацад Сүхбаатар сумын Улсын тэргүүний 4 дүгээр сургуулийн 11а ангийн сурагч Э.Амгалантөр шалгарч, аймгийн “Оны шилдэг хүүхэд”-ийг 9 номинацаар, ерөнхий боловсролын 34 сургууль бүрээс шилдэг 1 хүүхдийг шалгаруулж, 1.9 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.

4.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2018 оны 11-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 731 байсан бол 116 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 83 ажлын байранд 24 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 78 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 745 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 12 сарын байдлаар 46,254 иргэнд 13,896,850,0 мянган төгрөгийг олгоод байна.

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2,735 иргэнд 4,297,952.8 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1,834 иргэнд 1,204,739.8 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1793 иргэнд 895,604.1 мянган төгрөг
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 5321 иргэнд 643,844.7 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 1451 иргэнд 284,024.0 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 3,245 эхэд 434,013.3 мянган төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 43 иргэнд 86,877.4 мянган төгрөг
- Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 8,690 иргэнд 1,145,120.0 мянган төгрөг
- Насны хишиг 4,526 иргэнд 692,770.0 төгрөг
- Цалинтай ээж хөтөлбөр 6,856 иргэнд 3,048,793.1 мянган төгрөг
- Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр 230 иргэнд 173,760.0 мянган төгрөг
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ 230 иргэнд 14,352.0 мянган төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 7080 иргэд 946,702.8 мянган төгрөг
- Ахмад настны үйлчилгээ 2220 иргэнд 28,296.0 мянган төгрөг

Сумдын Хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангах сургалт, семинарыг 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр зохион байгууллаа.

5.Нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Нийгмийн даатгалын шимтгэлийн 29.3 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөтэйгээс 31.3 тэрбум төгрөгний орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 106.7 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны үйлчилгээг 571 иргэд, даатгуулагчдад үзүүллээ.

Тэтгэврийн даатгалын сангаас 16421 тэтгэвэр авагчдад 60486.63 сая төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 6999 хүнд 2601.24 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 310 хүнд 1974.37 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 524 хүнд 822932.8 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжийг тус тус олгожээ.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нийт 4 удаагийн хурал хийж, 347 иргэний материалыг хэлэлцэн 27 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг цуцалж, 58 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг шинээр тогтоож, 262 иргэний актыг сунгасан байна.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Улаанбуудайн урамшууллын материалыг аймгийн хэмжээнд нэгтгэж, нийт 232 аж ахуйн нэгж, иргэний материалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлээд байна.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, “Ногоон алт” төсөлтэй хамтран хөтөлбөрт хамрагдсан Алтанбулаг, Цагааннуур, Сант, Орхон, Орхонтуул, сумдын бүлгийн ахлагч, төлөөлөгчдийн хамруулсан зөвлөгөөнийг зохион байгуулж, бэлчээрийн өнөөгийн байдал, хэрэгжүүлсэн ажлаа тайлагнаж, цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргалаа.

Сүхбаатар, Хушаат Алтанбулаг зэрэг сумдаас ирсэн мал, амьтны халдварт өвчний сэжиг бүхий дуудлага бүрт шуурхай зөвлөгөө, зөвлөмжийг өгч шуурхай хариу арга хэмжээг авч ажилласан. МЭАЦЛ-ийн иилдэс судлалын шинжилгээнд Сүхбаатар сумаас 12, Хушаат сумаас 2, нийт 14 иилдэс судлалын шинжилгээг стандартын дагуу хийж халдваргүй болохыг тогтоосон. Сүхбаатар сумын худалдааны төв, нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж буй МАА-ны гаралтай мах, махан бүтээгдэхүүний адууны 3425 кг махны 23 дээж, үхрийн 16214 кг махны 101 дээж, хонины 2674 кг махны 86 дээж, ямааны 20 кг 126махны 23 дээж, гахайны 984 кг махны 14 дээж нийт мах, махан бүтээгдэхүүний 20643 кг махны 350 дээж, 125 л сүүний 6 дээжин, МЭАЦ-ийн магадлан шинжилгээ хийж ариун цэврийн гэрчилгээ олгосон.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын вакцинжуулалтыг аймгийн Засаг даргын 2018 оны А/394 тоот захирамжаар технилоогт хугацаанд 11 сумын 22 МЭҮН 110204 бод, 6480 гахай 250 хонь нийт 116934 толгой мал, амьтанд нэг удаа тус тус хийж гүйцэтгэлээ.

Улаанбаатар хотноо 12-р сарын 4-ний өдөр зохион байгуулагдсан Үндэсний аварга шалгаруулах үсчин, гоо засалч, хумс дизайн урлалын 24-р их наадамд тус аймгаас 14 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож, 3 алт, 1 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж, аймгийн үсчин, гоо засалчдын холбоо “Шилдэг холбоо”-оор шалгарлаа.

Сүхбаатар суманд үсчин, гоо сайхны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийнүйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөн туслах ажлыг 5 байгууллагын хамтарсан ажлын хэсэг энэ сарын 5-7-ны өдрүүдэд зохион байгуулж, 15 үсчин, 5 гоо сайхны салоныг хамруулж, “Үс засах үйлчилгээ” MNS 5160:2002, “Гоо сайхны хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Гоёлын гоо заслын үйлчилгээнд тавих шаардлага” MNS 5567:2006 стандартын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийхэд үсчнийх дунджаар 65,1 хувьтай, гоо сайхных 61.6 хувьтай дүгнэгдлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын Тогооч нарын холбоотой хамтран “Монголын тогооч нарын холбооны 25 жилийн ойн баяр”, “Улсын аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан” Улаанбаатар хотод зохион байгуулагдсан бөгөөд тус аймгаас Сүхбаатар, Ерөө, Шаамар, Мандал, Сайхан, Жавхлант сумдын 19 тогооч оролцлоо. Уралдаанаас Ерөө сумын К.Түмэнжаргал “Эмчилгээний хоолны төрөл”-д хүрэл медаль хүртэж, Монголын тогоочдын холбооны

“Тогоочийн одон”-гоор 5 хүн, “Залуу тогоочийн алтан медаль”-аар 3 хүн, “Хүндэт тэмдэг”-ээр 1 хүн шагнагдлаа.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

Аймгийн хэмжээнд геодези зураг зүйн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл 4 аж ахуй нэгж тогтмол үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд тэдгээр компаний техник, багаж хэрэгслийн баталгаажуулалт, батлагдсан солбицлын тогтолцооны дагуу зураглал үйлдэж байгаа зэрэгт 1 удаагийн хяналт шалгалт хийсэн. Мөн 17 сумын газрын даамлуудад геодези зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компаниудтай цаашид холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрхэн хамтарч ажиллах талаар мэдээлэл, зөвлөмж өгсөн.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2003 оноос хойш шинээр суулгасан болон хуучин цэг тэмдэгтийн жагсаалт, судалгааг үндэслэн аймгийн хэмжээнд 877 цэгийн хувийн хэрэг байгаагаас өндрийн сүлжээний-49, гравиметрийн сүлжээний-3, триангуляцын сүлжээний-391, полигонометрийн сүлжээний-65, GPS-ийн сүлжээний-369 цэг тэмдэгт бүртгэлтэй байна. Мөн аймгийн Засаг даргын цэг тэмдэгтийн тооллого хийх тухай 2018-10-22 өдрийн 1/771 тоот бичгийг сумдын Засаг даргад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан ба үүний дагуу 14 суманд цэг тэмдэгтийн тооллогын ажил хийгдэж нийт 121 цэг тэмдэгт тооллогод хамрагдсанаас 16 цэг устсан бөгөөд 6 цэгийн хувийн хэрэг үүсээгүй байгаа талаар дүн мэдээлэл нэгтгэгдсэн. Сүхбаатар, Мандал суманд суурилуулсан байнгын ажиллагаатай станцын өндрийн алдааг шалгаж үр дүнг тухай бүр [\192.168.20.24\AimagIT\GNSS-files-д](#) хуулах ажлыг гүйцэтгэсэн.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 32 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сан Лэнд менежер програмд бүртгэж баталгаажуулсан. Мөн Сүхбаатар сумын 54 иргэнд шинэчилсэн хаягаар кадастрын зургийг үнэт цаасан дээр хэвлэн иргэдэд үйлчилсэн байна.

Дараах барилга байгууламжид улсын комисс ажиллалаа. Үүнд:

– Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн ЗДТГазрын захиалгаар баригдсан Хүдэр сумын ЗДТГазрын өргөтгөлийн барилга угсралтын ажил

– Мандал суманд баригдсан Мандал суман дахь ШШГХэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн ажилчдын 28 айлын орон сууцны барилга угсралтын ажил

– Мандал сумын нэгдсэн эмнэлгийн лифтний барилгын угсралтын дуусаж барилга байгууламжийн ажил

– Мөн Мандал сумын Түнхэл тосгонд Иргэн Ч.Оюунгэрэлийн “Шатахуун түгээх станцын барилга”-ын ажил

– Баруунбүрэн суманд хийгдсэн Сургуулийн барилгын сантехникийн засварын ажил

– Хушаат суманд баригдсан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын захиалгаар “Хан Аттрибут” ХХК –ийн гүйцэтгэсэн 20 метр өндөр Цамхаг болон 9x12 метрийн харьцаатай “Харилцаа холбооны нэг цэгийн үйлчилгээний төв” –ийн барилгын угсралтын ажил дууссан тухай захиалагч байгууллагаас улсын комисс ажиллаж өгнө үү гэсэн албан хүсэлтийн дагуу тус барилга угсралтын ажил

– Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7-р багт баригдсан “Улаанбаатар төмөр зам” –ын Сүхбаатар зангилааны 32 айлын орон сууцны барилгын ажил

– Номгон тосгоны сургуулийн барилгын засварын ажил

– Хушаат суманд баригдсан цэцэрлэгийн барилгын өргөтгөл / 50 ортой/ -ийн барилга угсралтын ажил

– Ерөө сумын Бугант тосгонд баригдсан Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын сургалт мэдээллийн төвийн барилга угсралтын ажил

–

Долоо. Байгаль орчин, аялал жуулчлалын хүрээнд

“Уур амьсгалын өөрчлөлт-хариу арга хэмжээ” сэдэвт семинар, хэлэлцүүлгийг салбар тус бүрийн төлөөлөл нийт 65 хүнийг хамруулан зохион байгуулсан. Семинар, сургалтын үеэр салбар бүр мэдээлэл хийж, “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн II шатны төлөвлөгөөнд санал авсан.

“Уур амьсгалын өөрчлөлт-Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт” Үндэсний чуулганд “Тужийн нарсны ойжуулалтын ажлын ололт амжилт, үр дүн” сэдвээр илтгэл тавьж оролцсон. Уг үндэсний чуулганд 21 аймгийн 680 гаруй төлөөлөгч оролцсон.

Төсөл, хөтөлбөрийн газартай хамтран “Ойн мэргэжилтэй ажилтан бэлтгэх нь” хэлэлцүүлэгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 8 сумын 30 гаруй нөхөрлөлийн гишүүд хамрагдсан.

Ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудад ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ойн тухай хуулийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулж Алтанбулаг, Баруунбүрэн, Хүдэр, Ерөө, Мандал, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Сант зэрэг сумдын ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудын явуулахад холбогдох албан тушаалтнууд 300 гаруй иргэн хамрагдсан.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төвлөрүүлэх аяны удирдамжийг боловсруулан батлаж 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд 17 суманд зохион байгуулсан. Аяны үр дүнг дүгнэж байна.

“Байгаль орчны салбарын зөвлөгөөн 2018” семинарыг 2018 оны 12 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд сумдын байгаль хамгаалагч, сумын болон сум дундын Ойн ангийн дарга, инженер, техникийн ажилчдыг хамруулан зохион байгуулсан. 2018 оны үйл ажиллагааныхаа үр дүнг хэлэлцэн 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлын зорилго, зорилтоо тодорхойлсон.

Хүдэр, Ерөө, Мандал сумдад 2016-2017 онд хийгдсэн Ой зохион байгуулалтын ажлын материалыг БОАЖЯ-ны “Ойн нөөцийн мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулсан. Тус материалыг үндэслэн Хүдэр, Ерөө, Мандал сумдын ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийн ойн менежментийн төлөвлөгөөг хянасан.

Найм.Сум орон нутгийн талаар

Алтанбулаг сум:

Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнаж, мэдээлэл хийлээ.

2018 оны жилийн эцсийн мал тооллогоор сумын хэмжээнд нийт 55,571 толгой мал тоолуулснаас адуу 3291, үхэр 9337, тэмээ 2, хонь 25454, ямаа 17487 толгой тоологдлоо.

Сумын Соёлын төвийн дэргэдэх хөгжим, бүжгийн дугуйланд нийт 56 сурагч хамрагдан суралцаж байна.Сар бүрийн 20-ны өдрийн "Дуулах өдөр дуун цэнгүүн"-арга хэмжээг энэ удаа “Дамбо” цэцэрлэгийн хамт олон "Ахмадаа дээдэлсэн Алтанбулагчууд" нэртэйгээр зохион байгуулж, ахмадуудын дунд "Караоке", дуу, бүжгийн тэмцээнийг явууллаа. Мөн 7 хоног бүрийн баасан, бямба гаригт нийтийн цэнгээнт бүжгийг зохион явуулж,шинэчлэгдсэн 18 бүжгийг заалаа.

Сумын эрүүл мэндийн төвөөс 1, 2, 3-р багаас сүүлийн 3 жилд сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн судалгааг ТХТ-6 маягтаар хөтлөн, өвчилсөн 40 хүнийг бүртгэж, тэдний хавьтлыг өрх багийн эмч нар, багийн Засаг дарга нарын бүртгэл судалгаатай тулган шинэчиллээ. Сүрьеэгийн эрсдэлтэй болон эмзэг бүлгийн нийт 236 иргэд байна.

12-р сарын 1-нд “ДОХ-той тэмцэх дэлхийн өдөр”-өөр эрсдэлт бүлгийн иргэдэд шинжилгээ хийж, суманд үйл ажиллагаа явуулдаг 5 зочид буудлын нийт 50 өрөөнд 2019 оны календарь бүхий ДОХ, ХДХВ, БЗДХ–ээс сэргийлэх санамж байрлууллаа.

Мандал сум:

Сумын ИТХ-ын XVII хуралдаан 12-р сарын 19-ний өдөр хуралдаж сумын ИТХ-ын 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж хангалттай дүгнэж, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эхний 2 жилийн хэрэгжилтийн биелэлтийг 90,1 хувь буюу хангалттай гэж дүгнэлээ. Сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 91,7 хувьтайгаар, сумын 2019 оны төсвийн гүйцэтгэлийн орлогын нийт дүнг 1,330,374,3 төгрөгөөр баталж, Сум хөгжүүлэх сангийн төсвийг хэлэлцэж нийт 276,8 сая төгрөгөөр баталлаа. Мөн сумын 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Сумын “Мал тооллогын ажлын хэсгийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан томилж, 48 тооллогч ажиллан 10 хоногийн хугацаанд 1175 мал бүхий өрх, 597 малчин өрх, 10 аж ахуйн нэгж, байгууллагын 94472 мал тоологдож өнгөрсөн оны мөн үеэс 7,1%-иар буурсан. Мөн 5460 тэжээвар амьтан тоологдлоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 413-р ангийн албан хаагчдын 28 айлын орон сууц, Нэгдсэн эмнэлгийн лифтын барилга ашиглалтад орж, Хэрх тосгоны эрүүл мэндийн төвийн барилгыг ашиглалтад оруулахад бэлэн боллоо. Мөн 2015 онд ашиглалтад орсон 15,8 км асфальтан замын барилгын ажлыг гүйцэтгэсэн “Замын битум” ХХК-ий 3 жилийн чанарын баталгаат хугацаа дуусч албан ёсоор ашиглалтыг орон нутагт хүлээлгэн өглөө.

Сумын шинэ суурьшлийн бүсийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1, 6-р багийн 6 кВ-ын агаарын шугамууды нтодорхой хэсгүүдийг буулгаж кабель шугамаар сольж, шинээр 6-р багт РП барих ажлыг эхлүүлээ.

126 айл, 96 айл, 36 айл, 24 айл, 18 айлын орон сууцууд, Түнхэл тосгоны дэд станцуудын хэрэглэгчдэд 2392 ширхэг ухаалаг тоолуур шинээр суурилуулж, 6 аж ахуйн нэгж, байгууллагын тоолуурыг ухаалаг тоолуураар солих ажлыг хийлээ. Мөн АТП-142, АТП-156, АТП-153 дэд станцуудыг засварлаж, модон порталыг төмөр бетон тулгуураар сольж шинэчилсэн.

2018 онд нийт 228 айл өрхийг шинээр хүчдэлд холбож, 380 гаруй айл өрхийн хүчдэлийг сайжруулж, 200 гаруй модон тулгуурыг бетон тулгуураар сольж, 3 дэд станцыг шинэчилж, 1 дэд станц шинээр барьж, 9 км 0,4 кВ –ын сипутас шинээр татаж, 2392 ширхэг ухаалаг тоолуурыг шинээр суурилууллаа.

Нийтийн номын сангийн шинэ уншигчаар 280 хүн бүртгэснээс гэрээр ном олгох карт 10 хүнд олгож, 1480 иргэнд 2310 ном хэвлэлээр үйлчиллээ. WiFi, интернэт үйлчилгээг уншигчдад хүргэж, шинэ мэдээллээр хангаж сонсдог номыг уншигчдад уншууллаа. MonBibilo программын цахим бүртгэлд шинээр карт нээлгэсэн 280 уншигчийг программд бүртгэлээ. Зөөврийн номын үйлчилгээгээр 7-9 баг Мишээл цэцэрлэгийн ажилтан албан хаагчдад үйлчилгээг үзүүлж 150 ш ном олголт хийлээ.

Номын сурталчилгааны ажлаар Ардын аман зохиол 15 ш нийт 20 ш номоор уншлагын танхимуудад үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

“Мандал сумын оны шилдэг хүүхэд” шалгаруулах “Харшийн сүлд модны наадмыг 6 дахь жилдээ МХДБЧ-т амжилттай зохион байгуулж 10 номинацаар шилдэгүүдээ тодруулж өргөмжлөл, цом, ивээн тэтгэгч байгууллагуудын гарын бэлэг болон хамтран ажилладаг 30 гаруй аж ахуй нэгж байгууллагууд хүүхдүүдэд бэлэг өгч баярлуулсан.

Сант сум:

Сумын хэмжээнд мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2018 оны жилийн эцсийн тооллогын ажлыг зохион явуулах тухай сумын Засаг даргын А/83 тоот захирамжаар ажлын хэсэг томилогдон сумын нутаг дэвсгэрийн 21 чиглэлд 49 хүн, 7 машин хамрагдаж, тооллогын ажилд 974800 төгрөгийн зардал зарцуулагдсан байна.

2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр тэмээ 10, адуу 4797, үхэр 11096, хонь 40773, ямаа 26959, бүгд 83635 толгой мал тоологдсон байна. Тэжээвэр амьтад 12 өрхийн 105 гахай, 16 өрхийн 283 тахиа шувуу, 263 өрхийн 334 хашаа, 53 өрхийн 59 худаг тоологдсон дүнтэй байна. Хяналтын тоонд 17 өрхийн 8314 толгой мал хамрагдсан.

Улс тунхагласны баярын өдрийг тохиолдуулан сумын ИТХ, ЗДТГ-аас Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж 16 нас хүрч байгаа 11 сурагч тангараг өргөж иргэний үнэмлэхээ гардан авсан байна. Цахим үнэмлэхээ гардан авсан ахлах ангийн 11 сурагчдад “Монгол Улсын Үндсэн хууль” цахим хичээлээр мэдээлэл хийсэн байна.

Сумын Засаг даргын Тамгын газар, ЕБС, 13-р цэцэрлэг хамтран “Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо” эцэг эхийн чуулганыг зохион байгууллаа. Эцэг эхчүүдийг 4 өртөөгөөр аялуулж, “Үдийн цай” хөтөлбөрт амталгаа хийлгэж, “Хүүхэд хамгаалал”, Хүүхэд хамгааллын хамтарсан багийн тухай ойлголт, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал”, Хүн худалдаалах гэмт хэргийн тухай, Боловсролын салбарт хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгүүд, эцэг эх багш, сурагчийн гурвалсан холбоог сайжруулах, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх, хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо, үүрэг хариуцлага, ЕБС-ийн өнөөгийн үйл ажиллагаа сургалтын чанар сэдвээр сургалт зохион байгуулж арга хэмжээнд 192 иргэн хамрагдсан байна. Арга хэмжээний хүрээнд хүүхэд аюулгүй орчин санал асуулгыг Сайхан сумын цагдаагийн хэлтэстэй хамтран ЕБС-ийн 93 хүүхдээс авлаа. Эцэг эхийн чуулганаас бага ангийн сурагчдыг “Гараас гарт өгөх журам”-ыг мөрдүүлэх, цэцэрлэгт “School police” эцэг эхийн эргүүл ажиллуулах зэрэг санал санаачлагыг дэмжиж, эцэг эхчүүдэд хандсан 10 зөвлөмж гаргасан байна.

Мөн сумын Засаг даргын Тамгын газраас Эрүүл мэндийн төвтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо, тэгш байдлыг хангаж, эрх мэдэлжүүлэх” сэдэвт эрүүл мэндийн өдөрлөг, сургалт хэлэлцүүлгийг 12-р сарын 5-нд зохион байгуулж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”, “Өргөдөл, гомдлын тухай ойлголт, өргөдөл бичих загвар” сэдвээр мэдээлэл хийж Эрүүл мэндийн төвөөс анхан шатны үзлэг, оношлогоо шинжилгээ хийж биеийн жин, индекс тодорхойлсон ба энэ арга хэмжээнд 37 хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан байна. Оролцогчдыг 3 бүлэгт хувааж “Тэгш байдал”, “Оролцоо”, “Эрх мэдэлжүүлэх” чиглэлээр тэдэнд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга хэмжээний талаар санал солилцсон байна.

“Авлигын эсрэг олон улсын өдөр”-ийг тохиолдуулан авлигын эсрэг хууль тогтоомжуудыг мэдээллэх, сурталчилах ажлын хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх” сэдвээр 32 албан хаагчдад мэдээлэл хийлээ.

Баянгол сум:

Тайлант сард сумын ИТХ-ын 14-р хуралдаан болж, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, сумын 2018 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2019 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл, 2018 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэл, 2019 оны төсвийг хэлэлцлээ. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжилтийг 82,6 хувьтай дүгнэгдлээ.

2018 оны жилийн эцсийн мал тэжээвэр, амьтад, хашаа худаг, усны тооллого явуулах сумын ажлын хэсгийг байгуулж, 51 хүний бүрэлдэхүүндтэй 12 тээврийн хэрэгслийг дайчлан ажиллууллаа. Тооллогод сумын дүнгээр 8959 адуу, 14796 үхэр, 71965 хонь, 43077 ямаа, нийт 138797 толгой мал, гахай 98, шувуу 1322, зөгийн 108 бүл тоологдлоо.

Сумын төв болон хөдөөгийн зарим малчдын өвөлжөөний орчим золбин нохой ихсэж хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, бэлчээрийн малд өвчин халдах, хүн

малын халдварт өвчний гаралт болох зохисгүй үр дагавар гарах эрсдлээс урьдчилан сэргийлж, нохой устгах ажлыг зохион байгуулж, нийт 96 золбин нохойг усгах арга хэмжээ авлаа.

Сумын халаалтын төвд гарсан гэмтлийг цаг алдалгүй засварлаж, нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх үүднээс Шарын голын уурхайтай гэрээ байгуулан 8 вагон нүүрсний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.

Олон Улсын хөгжлийн бэрхшээлийг иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Хамдаа хөгжье” өдөрлөгийг зохион байгуулж, хүн байхын учир, гэр бүлийн харилцаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын тухай хуулийн өөрчлөлт, эрүүл мэндийн төвийн үйлчилгээний мэдээлэл, дундын хадгаламжийн бүлийн сургалтууд болж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга хэмжээний талаар ярилцлага, хэлэлцүүлэг явуулж, дуун цэнгүүн, гар зургийн уралдаан, сайн үйлсийн аяныг тус тус зохион байгууллаа.

Сумын ИТХ-ын төлөөлөгч, ЕБ-ын сургуулийн сургалтын менежер санаачлан “Хар алт-Халуун сэтгэл” нүүрсний аяныг 2 дахь жилдээ тус сумын харъяат СЭЗИС-ийн оюутан Э.Цэнгүүнтэй хамтран “Өөрт байгаагаар өрөөлд тусалъя” уриан дор зохион байгуулж, 1-12 дугаар ангийн сурагчид хамрагдаж 478 шуудай нүүрс цугларсныг золрилтот айл өрхүүдэд олголоо. Мөн боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд “Нэг сурагч нэг ном” аяныг 1-ээс 5 дугаар ангийн дунд явуулж, “Номын сан”-г 404 номоор баяжуулсан.

Баруунбүрэн сум:

Эцэг эхчүүдийн хүүхдээ хүмүүжүүлэх арга барилд санаа сэдэл өгөх, хүүхдийн эрх, хөгжил хамгааллын чиглэлээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэж гэр бүл, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 2018 оны 12-р сарын 18-ны өдөр “Хүүхдийн хөгжилд-эцэг эхийн оролцоо” зөвлөгөөнийг сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Д.Мягмарын нэрэмжит ЕБС, 25-р цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, сум дундын Прокурорын газар хамтран зохион байгуулж сургуулийн эцэг эхийг зөвлөлийн дарга, эцэг эхийн төлөөлөл зэрэг нийт 130 гаруй хүнийг оролцуулж, охидын, хөвгүүдийн, ээжүүдийн, аавуудын, цэцэрлэгийн гэх мэт салбар зөвлөгөөнүүдийг зохион байгууллаа. Энэ үеэр “Хүүхдийн хүмүүжил төлөвшил, тулгамдсан асуудал ба шийдэл” сэдэвт итгэлийг тавьж, 2018 онд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын талаар болон “Өсвөр насны хүүхэд холбогдсон болон хохирсон” гэмт зөрчлийн, “Авто замын осол” түүнээс сэргийлэх шинэчилсэн хууль дүрмүүдийг танилцуулж, “Гэр бүлийн эелдэг харилцаа” сэдвээр лектор Ш.Алтанцэцэг, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдвээр нийгмийн ажилтан Ц.Мөнхжаргал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөрийн хүрээнд Эко-сургууль болох талаарх мэдээллийг Багш Б.Булгангэрэл, хамтарсан багийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг НБХЭХ мэргэжилтэн Т.Бүрэнжаргал нар хийлээ. Зөвлөгөөнд оролцсон оролцогчдоос гарсан уриалга зөвлөмжийг баталлаа.

Тайлант сард цэцэрлэгийн аав ээжүүдийн дунд гар бөмбөгийн тэмцээн, сургуулийн эцэг эхийн дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулагдлаа.

Сумын эрүүл мэндийн төвөөс байнгын асаргаанд байдаг хэвтрийн 10 өвчтөнд гэрийн асаргаа сувилгаа хийж, асран хамгаалагчдад мэдлэг мэдээлэл өгч, үзлэг хийгдлээ. “Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн зохистой хэрэглээнд сөргөөр нөлөөлөх зан үйлийг өөрчлөх, эмийн буруу хэрэглээнээс үүдэлтэй нянгийн эсрэг эмийн тэсвэртэй байдалд хяналт тавьж” 30 хүнд ухуулга сурталчилгаа мэдээлэл өгсөн. “Антибиотикийн зохистой хэрэглээ”-ний тухай амбулаториор үйлчлүүлж буй хүмүүст 300 ширхэг зөвлөмж боловсруулан тараах материал тараав.

Эрсдэлт бүлгийн хүн амд буюу ЕБС-ийн 10,11-р ангийн хүүхдүүдэд БЗДХ/ХДХВ халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх, халдварын тархалтыг бууруулах чиглэлээр мэдээлэл сургалт сурталчилгааг явууллаа. Мөн Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын баг

хамт олон Баруунбүрэн суманд ирж ард иргэдэд халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэгийн үзлэг 2018-11-30, 12-р сарын 01,02-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэ үеэр ДОХ-той тэмцэх дэлхий нийтийн өдөрт ард иргэдэд малчдад нийт 300 гаруй гарын авлага тараах материал тараалаа

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн салбараас зохион байгуулж буй Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, сумын хүн амын эрүүл мэндийн мэдээллийн цахим санг бүрдүүлэх цогц үзлэг оношлогоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүүхдүүдийг хамрууллаа.

2018 оны жилийн эцсийн байдлаар Хагас өнчин хүүхэд 39, бүтэн өнчин хүүхэд 4, Өрх толгойлсон эцэг эх 164, арван найм хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойсон эцэг эх 57, хоёр ихэр хүүхэдтэй өрх 8, Алдарт эхийн 1-р одонтой эх 106, 2-р одонтой эх 191, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 121, үүнээс хүүхэд 24 байна.

Жавхлант сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаан 12-р сарын 20-ны өдөр болж, сумын 2018 оны төсвийн төсөл, 2019 оны төсөв, сумын 2019 оны үндсэн чиглэлд нэмэлт оруулах тухай, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Мөн сард сумын Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа, төр төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч болон албан хаагчдын шуурхай хурал 4 удаа, үнийн зөвшлийн хурал 1 удаа хуралдлаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, төр төсвийн байгууллагууд бодлогын баримт бичиг, хяналт шинжилгээ үнэлгээний жилийн эцсийн тайлан, 2018 оны сумын шилдэг малчин, тариаланч, аж ахуйн нэгжүүдийн тодорхойлолтыг хүргүүлэн ажиллалаа.

Сумын хэмжээнд малчин өрх 275, мал бүхий өрх 123, 2018 оны 12-р сарын 20-ны байдлаар 88156 мянган толгой мал тоологдож, өмнөх оныхтой харьцуулахад 6.8% өссөн байна.Үүнд:Үхэр 10266 мянган толгой буюу 2.06%, адуу 4945 мянган толгой буюу 5.4%, хонь 41251 мянган толгой буюу 5.6%, ямаа 31694 мянган толгой буюу 10.1%-иар өссөн байна.

Аймаг, сумын Засаг даргын захирамжаар 2019 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэл 12-р сарын 25-наас 01-р сарын 15-ны хооронд явагдаж байна.

Аймгийн гэр бүл хөгжлийн газрын мэргэжилтэн н.Оюунжаргал, Улаанбаатар хотын хүүхдийн эрх хамгааллын төвийн захирал н.Ундраа нар сумын хамтарсан багийн гишүүдийг ажлын байранд нь чадавхижуулах сургалтыг зохион байгуулж гарын авлага, тараах материал өглөө.

Шинэ жилийн баяр болж байгаатай холбогдуулан ЗДТГ-ын даргын А/48 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэгтус суманд үйл ажиллагаа явуулж буй нийт 5 хүнсний дэлгүүрүүдийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүүхдийн бэлэгний чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Уг шалгалт хийх явцад хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн болон үйлдвэрлэсэн хугацаа тавигдаагүй хаяг шошгын зөрчилтэй хүнсний бүтээгдэхүүн худалдаалж байгаа зөрчил дутагдлууд илэрлээ.

Сумын эрүүл мэндийн төвөөс энэ сард нийт 136 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх 47, амбулаторын үзлэг 21, идэвхитэй хяналт 25, гэрийн идэвхитэй үзлэг 43 хийгдсэн байна. Эрүүл мэндийн төвөөс урьдчилан сэргийлэх үзлэг, элэгний В,С вирус илрүүлэх, хеликобактер илрүүлэх түргэвчилсэн оношлуулаар 40 иргэнд үзлэг хийлээ.

26-р цэцэрлэгийн авъяаслаг бяцхан хүүхдүүдийн дунд урлагийн анхдугаар уралдааныг зохион байгуулж шилдгүүдээ шалгаруулж эцэг эх, иргэдийн дунд тайлан тоглолт хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь улаан загалмайн хорооноос гамшигт өртсөн иргэдэд тусламж үзүүлэх, гамшгийн яаралтай үеийн сангаас гал түймрийн гамшигт өртсөн Моностой 2-р багийн иргэн Д.Мөнх-Очирийн гэр бүлд 800.000 мянган төгрөгийн эд материалын тусламж үзүүллээ.

Дэлхийн зөн Олон Улсын байгууллагаас эд хөрөнгөөр сумын ядуурлын түвшин

тогтоох судалгааны ажил хийлээ. Ядуурлын түвшинг тогтооход сумын 712 өрхөөс түүвэрчилэн 100 өрх сонгон ЗДТГ-ын төлөөлөл, Багийн Засаг дарга нар иргэдийн оролцоотойгоор ядуурлын түвшинг тогтоолоо.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан 3 өрхийн оноо бодогдож хүүхдийн мөнгөө бэлнээр авахаар боллоо. 2018 оны 11 сарын 21-ний өдрийн Засгийн газрын 351-р тогтоолоор Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдах хүсэлт гаргасан, эсхүл дахин үнэлгээнд хамрагдсан өрхийн хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинг үнэлсэн сараас эхлэн тооцож олгохоор боллоо.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд гар бөмбөгийн тэмцээн, караоке, азтан шалгаруулах арга хэмжээг зохион байгууллаа.

“Алтан хором” шинэ жилийн баяр зохион байгуулагдлаа. Сурлага, урлаг, спортын амжилтаараа бусдыгаа манлайлан 2018 оны шилдэг багш Б.Уянга, шилдэг ажилтан С.Одончимэг, шилдгийн шилдэг сурагч 9а анги Ч.Мөнхжин, сурлагын аварга сурагч 5а анги Б.Заяабаян, урлагийн аварга сурагч 11а анги Г.Ганбагана, спортын аварга сурагч 11а анги Б.Отгонням, спортын аварга сурагч 9а анги Б. Нандинчимэг сурлагын аварга анги П.Нямаа багштай 7а анги, спортын аварга анги Б. Байгальмаа багштай 11 а анги, урлагийн аварга анги А. Цэнд багштай 9а анги тус тус шалгарлаа.

Бумбат 1-р багаас санаачлан зохион байгуулсан "Сайн үйлсийн аян"-д ЗДТГ, ЕБСургууль, 26-р цэцэрлэг, С.Хашбатын гэр бүл хамтран оролцож тус багийн өндөр настан, ганц бие, өрх толгойлсон эмэгтэй Ч.Цагаанд тусламж үзүүллээ.

“Хүүхдийн хөгжил-эцэг эхийн оролцоо”, Хүүхэд-Монголын баялаг” сэдэвт зөвлөгөөн амжилттай зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд хүүхдийн сэтгэлзүйн мэргэшсэн зөвлөх багш лектор Ш.Алтанцэцэг “Хүүхдийн хүмүүжилд эцэг эх, орчин нөлөөлөх нь” сэдэвт сургамжит цуврал лекц уншиж, эцэг эх сурган хүмүүжүүлэгч иргэдэд үнэтэй, сургамжтай мэдээлэл түгээлээ. Зөвлөгөөнийг 26-р цэцэрлэг, ЕБСургууль хамтран зохион байгуулсан бөгөөд цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд "Бид дуучин- Найрал дуу-2018" тэмцээн зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Л.Бэрцэцэг, Д.Батцэнгэл багштай бэлтгэл бүлэг "Тэргүүн байр", Г.Атарцэцэг, Д.Оюунгэрэл багштай ахлах бүлэг "Дэд байр" тус тус эзэллээ.

Хушаат сум:

2018 оны жилийн эцсийн мал тооллогын сумын дүнгээр нийт 83517 мал тоологдсоноос адуу 3405, үхэр 11825, хонь 39038, ямаа 29249 толгой тоологдлоо.

Тайлант сард улс, аймгийн ургацын баярын шилдэг номинацид дэвшигчдийн тодорхойлолт, Улсын аварга тариаланч, аймгийн тариаланч, ногоочдын тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Тамгын газарт, улаанбуудайн урамшууллын материалыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүллээ.

Энэ сард байгаль орчны чиглэлээр 583 м3 модны зөвшөөрлийг олгож, айл өрхийн түлшний хэрэгцээг хангах арга хэмжээ авлаа.

Улсын бүртгэлийн үйлчилгээгээр төрөлт 1, биеийн давхцахгүй өгөгдлийн 5, үл хөдлөх хөрөнгийн эрхийн 2 цахим үнэмлэх дахин авах 2, газар өмчлөх эрхийн 8, нийт 48 бүртгэл хийж 1 гэрчилгээ бичиж олгосон. Шилжин ирсэн 14 хүн байна. Нийт 51 бүртгэл хийн 7 гэрчилгээ бичиж олгосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Улсын төсөв болон мэдээлэл харилцаа холбооны сүлжээний хөрөнгө оруулалтаар шилэн кабелийн барилгын ажлууд хийгдлээ.

Нийгмийн даатгалын шимтгэлд 5 байгууллага, 29 аж ахуйн нэгжийн 327704,0.0 мянган төгрөгийн, сайн дурын даатгуулагч 138 хүний 37817,4 мянган төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 138 хүний 37817,4 мянган төгрөгийн хураамжийг тус тус оруулж, шинээр тэтгэвэр тогтоолгох 25 хүний, шилжин ирсэн 5 хүний материалыг баталгаажуулан тэтгэвэр тогтоолгох талаар зөвлөгөөг 53 хүнд,

эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах зөвлөгөөг 714 хүнд өгч үйлчиллээ.

Сумын эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн 46 дуудлага ирснээс алсын дуудлага 8, артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 50, чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 50, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүүхдийн тоо 22, шинжилгээнд хамрагдсан хүний тоо 25, умайн хавдар хөхний хавдар илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 36, элэгний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 159 хүн байна.

ЭМТөвөөс энэ сард “Сэтгэцийн эрүүл мэнд” сургалтыг зохион байгуулж 50 хүн хамрагдаж гарын авлага, зөвлөмж тараав. Энэ сургалтанд 145.000 төгрөгийг зарцуулжээ.

Цэцэрлэгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөний биелэлт 12-р сарын 03-аас 12-р сарын 31-ний байдлаар хамран сургалт нийт 2200 хүүхэд хүлээн авахаас 1557 хүүхэд авч ирц 70.7 хувьтай байна. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх “Цөм” хөтөлбөрийн дагуу бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлж үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна.

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН :

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ш.ЭНХМАА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ө.СУВДАА